# ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дүгээр сарын 24 өдөр Дугаар 41 Хэрлэн сум

## XLI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 41 дүгээр хуралдаан 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 18:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

<u>СОНССОН НЬ:</u>

1.Монгол Улсын Засгийн газрын "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 2021 оны 104 дүгээр тогтоолыг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

2.Хөлөнбуйр хяналтын цэгээр нэвтэрч буй иргэдэд түргэвчилсэн шинжилгээ авах тухай тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

3.Хэрлэн сумаас бусад сумд руу очсон иргэдийг 7 дахь хоногт давтан шинжилгээнд хамруулах, 14 хоног гэрт нь тусгаарлах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

4.Дорнод их сургуулийн 1 давхарын баруун жигүүрийн өрөө, тасалгаанд аймгийн Шуурхай штабыг шилжүүлэх тухай танилцуулах,

5.БНХАУ-ын ӨМӨЗО-оос Дорнод аймагт үзүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтоос татаж авах зардлын тооцоог танилцуулах,

*АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс*

6.Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч нарыг вакцинжуулах тухай албан бичгийг танилцуулах,

*Зэвсэгт хүчний 327 дугаар анги*

7.Аж ахуй нэгж байгууллагуудаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

/ /М.Бадамсүрэн

/ / Д.Баттулга

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Монгол Улсын Засгийн газрын "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 2021 оны 104 дүгээр тогтоолын гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссын 33 дугаар тогтоолыг цуцалж тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Хөлөнбуйр хяналтын цэгээр нэвтэрч буй иргэдэд түргэвчилсэн шинжилгээ авах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Хэрлэн сумаас бусад сумд руу очсон иргэдийг 6 дахь хоногт давтан шинжилгээнд хамруулах, 14 хоног гэрт нь тусгаарлах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Дөрөв.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа -д:

4.1.Дорнод их сургуулийн 1 давхарын баруун жигүүрийн өрөө, тасалгаанд аймгийн Шуурхай штабын ажлын хэсгийг шилжүүлэх,

Тав.Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагч, хурандаа Н.Цэцэнхүү-д:

5.1.Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас сумдын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй 33 албан хаагчдыг татаж вакцинжуулалтад хамруулах ажлыг зохион байгуулах,

5.2.Зэвсэгт хүчний жанжин штабаас томилогдсон Дорнод аймгийн хилийн ангиудын албан хаагч нарт эрүүл мэндийн үзлэг хийх, вакцинжуулалтад хамруулах ажлаар Халхгол сум руу нэвтрэх хүсэлтийг зөвшөөрөв,

Зургаа.АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг, АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх нарт:

6.1."Петрочайна дачин тамсаг" ХХК-д хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газраас албан бичгээр чиглэл хүргүүлэх,

Долоо.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

7.1.БНХАУ-ын ӨМӨЗО-оос Дорнод аймагт үзүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтоос татаж авахыг зөвшөөрөв, зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

/ /М.Бадамсүрэн

/ / Д.Баттулга

Найм.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

8.1.Улсын Онцгой комиссоос гаргасан Эрсдэл аппликешныг ашиглах талаар төрийн байгууллагуудад албан бичгээр чиглэл хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

ТУ32095 0720030013 9029346